ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тайшир сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ГАА-2022/94/-НА-СТА-ТШЗ**


Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Аудитор Б.Нямдорж
Утас: 99998436 Цахим хаяг: bnyamdorj5@gmail.com

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2022 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .......... 2.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .......... 3.
3. Аудитын тайлан .......... 8
   3.1 Ерөнхий зүйл .......... 9
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .......... 10
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .......... 11
   3.4 Материаллаг байдал .......... 11
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .......... 12
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .......... 12
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .......... 13
   3.8 Аудитын гол асуудал .......... **13.**
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .......... 13
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .......... 14
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .......... 14
4. Аудитын илрүүлэлт .......... 14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .......... 16

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E –mail: govialtai@audit.gov.mn

2022.02.28 № 142

танай ______ -ны № ______ -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТАЙШИР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ш.ДАВААСҮРЭН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тайшир сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тайшир сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

07020258

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **71,403,882.21** | **78,015,355.23** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **71,403,882.21** | **78,015,355.23** |
| **35100** | **Түүхий эд материал** | **8,058,862.00** | **9,501,831.60** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 7,679,362.00 | 8,175,771.60 |
| 35130 | Эм боох материал | 379,500.00 | 1,326,060.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **63,345,020.21** | **68,513,523.63** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 159,000.00 | 159,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 34,742,715.21 | 34,603,815.21 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,594,815.00 | 115,028.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 24,348,490.00 | 32,135,680.42 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **957,238,709.09** | **906,996,197.66** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **957,238,709.09** | **906,996,197.66** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **927,439,209.09** | **877,271,697.66** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 952,357,209.46 | 952,357,209.46 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (129,283,840.74) | (164,878,127.70) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 91,170,472.40 | 72,857,365.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (61,184,467.63) | (39,979,260.00) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 67,565,094.17 | 52,751,094.97 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (42,537,758.71) | (36,757,417.45) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 10,048,000.00 | 10,048,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (10,048,000.00) | (10,048,000.00) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 57,481,623.00 | 55,800,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (8,129,122.86) | (14,879,166.62) |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **29,799,500.00** | **29,724,500.00** |
| 39301 | Програм хангамж | 780,000.00 | 780,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (592,500.00) | (667,500.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 29,612,000.00 | 29,612,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,028,642,591.30** | **985,011,552.89** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,028,642,591.30** | **985,011,552.89** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,028,642,591.30** | **985,011,552.89** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 267,825,940.10 | 267,825,940.10 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **(39,511,909.60)** | **(83,142,948.01)** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (43,718,445.40) | (39,511,909.60) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 4,206,535.80 | (43,631,038.41) |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | - | - |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 800,328,560.80 | 800,328,560.80 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,028,642,591.30** | **985,011,552.89** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **694,784,797.00** | **637,749,573.94** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **27,082,047.00** | **25,703,011.94** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **27,082,047.00** | **25,703,011.94** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **27,082,047.00** | **-** |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 27,082,047.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | - | 17,556,351.92 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | - | 8,146,660.02 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **667,702,750.00** | **612,046,562.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **489,878,900.00** | **464,177,000.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 489,878,900.00 | 464,177,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **10,385,950.00** | **5,116,062.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,772,150.00 | 4,374,862.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,613,800.00 | 741,200.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **167,437,900.00** | **142,753,500.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 167,437,900.00 | 142,753,500.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **690,578,261.20** | **680,593,356.20** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **690,578,261.20** | **680,593,356.20** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **650,361,267.53** | **660,049,764.98** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **402,996,517.00** | **378,826,890.00** |
| 210101 | Үндсэн цалин | 368,156,284.00 | 353,089,312.00 |
| 210104 | Урамшуулал | 34,840,233.00 | 25,737,578.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **50,661,863.33** | **49,810,858.51** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,628,341.33 | 35,080,073.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 3,709,826.40 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,208,375.00 | 2,966,040.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 801,744.00 | 732,009.53 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,023,403.00 | 7,322,907.78 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **122,348,187.00** | **140,490,322.27** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,853,967.00 | 2,766,642.27 |
| 210302 | Түлш, халаалт | 120,494,220.00 | 137,707,680.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 16,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **5,117,063.00** | **3,527,012.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 380,000.00 | 631,162.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,359,400.00 | 645,270.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 141,475.00 | 149,380.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 450,000.00 | 42,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,740,100.00 | 2,058,700.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,046,088.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **8,219,699.00** | **14,656,175.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 262,500.00 | 1,037,050.00 |
| 210502 | Хоол, хүнс | 7,637,199.00 | 13,569,125.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 320,000.00 | 50,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **880,500.00** | **2,260,200.00** |
| 210604 | Урсгал засвар | 880,500.00 | 2,260,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **260,000.00** | **140,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 260,000.00 | 140,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,329,800.00** | **936,700.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,533,800.00 | 936,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 220,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **57,547,638.20** | **69,401,607.20** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 200,000.00 | 850,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 57,347,638.20 | 68,551,607.20 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **40,216,993.67** | **20,543,591.22** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **13,447,350.00** | **9,529,400.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 2,518,200.00 | 6,131,400.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 8,772,150.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,157,000.00 | 3,398,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **10,590,713.00** | **378,977.73** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,590,713.00 | 378,977.73 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **16,178,930.67** | **10,635,213.49** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,178,930.67 | 10,635,213.49 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **4,206,535.80** | **(42,843,782.26)** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **-** | **787,256.15** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | - | 787,256.15 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **4,206,535.80** | **(43,631,038.41)** |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **669,584,450.00** | **612,046,562.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **669,584,450.00** | **612,046,562.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 489,878,900.00 | 464,177,000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 489,878,900.00 | 464,177,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,267,650.00 | 5,116,062.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,653,850.00 | 4,374,862.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,613,800.00 | 741,200.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 167,437,900.00 | 142,753,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 167,437,900.00 | 142,753,500.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **636,084,450.00** | **610,506,562.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **636,084,450.00** | **610,506,562.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **595,867,456.33** | **589,962,970.78** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 402,996,517.00 | 378,826,890.00 |
| 210101 | Үндсэн цалин | 368,156,284.00 | 353,089,312.00 |
| 210104 | Урамшуулал | 34,840,233.00 | 25,737,578.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 50,661,863.33 | 49,810,858.51 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,628,341.33 | 35,080,073.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 3,709,826.40 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,208,375.00 | 2,966,040.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 801,744.00 | 732,009.53 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,023,403.00 | 7,322,907.78 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 122,348,187.00 | 140,490,322.27 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,853,967.00 | 2,766,642.27 |
| 210302 | Түлш, халаалт | 120,494,220.00 | 137,707,680.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 16,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,009,475.00 | 2,296,612.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 380,000.00 | 631,162.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,359,400.00 | 645,270.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 141,475.00 | 149,380.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 50,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 450,000.00 | 96,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,628,600.00 | 774,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 9,180,914.00 | 12,863,388.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 462,000.00 | 1,724,050.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,368,914.00 | 11,089,338.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 350,000.00 | 50,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 999,000.00 | 3,748,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 1,864,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 999,000.00 | 1,884,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 260,000.00 | 140,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 260,000.00 | 140,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,329,800.00 | 936,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,533,800.00 | 936,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 220,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,081,700.00 | 850,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,081,700.00 | 850,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **40,216,993.67** | **20,543,591.22** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 13,447,350.00 | 9,529,400.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 2,518,200.00 | 6,131,400.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 8,772,150.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,157,000.00 | 3,398,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 10,590,713.00 | 378,977.73 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 10,590,713.00 | 378,977.73 |
| 213404 | Хөрөнгийн | | |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 16,178,930.67 | 10,635,213.49 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,178,930.67 | 10,635,213.49 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **33,500,000.00** | **1,540,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **33,500,000.00** | **1,540,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **33,500,000.00** | **1,540,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 33,500,000.00 | 1,540,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(33,500,000.00)** | **(1,540,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **242,595,940.10** | **800,328,560.80** | **(36,626,492.40)** | **1,006,298,008.50** |
| 2 | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | - | - | **(7,091,953.00)** | **(7,091,953.00)** |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **242,595,940.10** | **800,328,560.80** | **(43,718,445.40)** | **999,206,055.50** |
| 4 | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | - | - | - | - |
| 5 | **Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт** | **25,230,000.00** | - | - | **25,230,000.00** |
| 6 | **Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз** | - | - | - | - |
| 7 | **Өмчид гарсан өөрчилөлт** | - | - | - | - |
| 8 | **Зарласан ногдол ашиг** | - | - | - | - |
| 9 | **Тайлант үеийн үр дүн** | - | - | **4,206,535.80** | **4,206,535.80** |
| 10 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **267,825,940.10** | **800,328,560.80** | **(39,511,909.60)** | **1,028,642,591.30** |
| 11 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **267,825,940.10** | **800,328,560.80** | **(39,511,909.60)** | **1,028,642,591.30** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| 13 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **267,825,940.10** | **800,328,560.80** | **(39,511,909.60)** | **1,028,642,591.30** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | - | - | - |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - | - |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | - | - | - | - |
| 18 | Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | (43,631,038.41) | (43,631,038.41) |
| 20 | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **267,825,940.10** | **800,328,560.80** | **(83,142,948.01)** | **985,011,552.89** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 606,930,500.00 | 595,916,308.78 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 606,930,500.00 | 595,916,308.78 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 596,386,100.00 | 586,386,908.78 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 385,388,000.00 | 378,826,890.00 |
| 210101 | Үндсэн цалин | 358,231,900.00 | 353,089,312.00 |
| 210104 | Урамшуулал | 27,156,100.00 | 25,737,578.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 51,296,700.00 | 49,810,858.51 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,572,900.00 | 35,080,073.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,680,900.00 | 3,709,826.40 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,944,800.00 | 2,966,040.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 736,200.00 | 732,009.53 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,361,900.00 | 7,322,907.78 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 140,868,700.00 | 140,490,322.27 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,000,000.00 | 2,766,642.27 |
| 210302 | Түлш, халаалт | 137,708,700.00 | 137,707,680.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 160,000.00 | 16,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,779,300.00 | 1,765,750.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 250,300.00 | 250,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 497,000.00 | 495,270.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 161,000.00 | 149,380.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 96,000.00 | 96,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 775,000.00 | 774,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 14,278,600.00 | 12,863,388.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,725,000.00 | 1,724,050.00 |
| 210502 | Хоол, хүнс | 12,503,600.00 | 11,089,338.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 50,000.00 | 50,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,884,800.00 | 1,884,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,884,800.00 | 1,884,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 150,000.00 | 140,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 150,000.00 | 140,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 490,000.00 | 355,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 490,000.00 | 355,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 250,000.00 | 250,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 250,000.00 | 250,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 10,544,400.00 | 9,529,400.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 7,144,400.00 | 6,131,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,400,000.00 | 3,398,000.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 0.00 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### 2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,116,062.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,116,062.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 5,116,062.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 530,862.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 380,862.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 150,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,404,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,404,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 581,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 581,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 600,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 600,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 5,116,062.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,116,062.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,374,862.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 741,200.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тайшир сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Шилэн баланс аудит” ХХК-ний Говь-Алтай салбарын аудитор Б.Нямдорж гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Тайшир сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймгийн Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд суралцагчдын бие даан суралцах үйлийг дэмжин хоцрогдолгүй сургах, хөгжил төлөвшил, эрүүл аж төрөх хэв маяг, зөв


Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

дадалд суралцах чадвар эзэмшүүлэхэд эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлж, хосолсон сургалтын орчин бүрдүүлэн ажиллах зорилго тавьсан. Улмаар зорилгоо биелүүлэхэд чиглэсэн 4 зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй. Харин Монгол Улсын засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тайшир сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны зардлын 655.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 13.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 10.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатны материаллаг байдлыг тайлант оны нийт зардлын 680.5 сая төгрөгөөс 2 хувиар тооцож шинэчлэн тогтоосон материаллаг байдал 13.6 сая төгрөг, шинэчлэн тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувь буюу 10.9 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тайшир сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.5 хувиар буюу 46.2 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Тайлант хугацаанд авлагагүй.

Бараа материалын дансны үлдэгдэл 78.0 сая төгрөг болж 6.6 сая төгрөгөөр өссөн нь бусад хангамж материал нэмэгдсэнтэй холбоотой. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 24.6 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 8.1 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 26.2 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,174.2 сая төгрөг болж 34.8 сая төгрөгөөр буурсан нь хөрөнгө актлаж, данснаас хассантай холбоотой.Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1.5 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 4.7 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансt, 14.2 сая төгрөгийг бараа материалын шилжүүлэн үнэ төлбөргүй хүлээн авсан бөгөөд ИТХ-ын тогтоолоор 55.3 сая төгрөгийн хөрөнгө актлаж, данснаас хассан байна.

Тайлант оны эцэст өглөггүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 985.0 сая төгрөг болж 43.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 9.1 хувиар буюу 59.0 сая төгрөгөөр буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл -83.1 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 993.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 386.8 сая төгрөгөөр бууруулж, 606.9 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс өндөр байгаа нь цалингийн зардал, тогтмол зардал, томилолт зочны зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 6 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 606.9 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 606.9 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 596.0 сая төгрөгийг зарцуулж 10.9 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 696.8 сая төгрөг буюу 98 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас 6.5 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд төлөх зардлаас 1.5 сая төгрөг, байр ашиглалтын зардлаас 0.4 сая төгрөг, норматив зардлаас 1.4 сая төгрөг,бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 0.1 сая төгрөг , төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллаас 1.0 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 5.1 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба 4.4 сая төгрөг дээд шатны байгууллагаас “Боловсрол шинэчлэл” төслийн санхүүжилт, сурах бичгийн түрээсийн орлого 0.6 сая төгрөг, 0.1 сая тендерийн бичиг баримтын үнийн орлогыг тайлагнасан.

Нэмэлт санхүүжилтийн орлогыг төслийн зардал болон тендерийн материалын зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 606.9 сая төгрөгийн 149 мэдээллийг ил тод байршуулахаас сая төгрөгийн 147 мэдээллийг ил тод байршуулсан байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 534.4 сая төгрөгийн орлогын гүйлгээ мэдээлээгүй байна

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд хүргүүлсэн албан шаардлагыг биелүүлсэн байна. биелүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар

- Нягтлан бодох бүртгэлийн бичилт
- Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудлыг авч үзэх
- Бараа материалын тайлангийн тулгалт,
- Хөрөнгийн чанар, хугацаандаа нийлүүлсэн эсэхийг шалгах
- Төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлсэн эсэхийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 7.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 2.5 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 5.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд зөвлөмж өглөө.



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### 4.1 Залруулсан алдаа

Үнэ төлбөргүй хүлээн авсан 2.5 сая төгрөгийн материалыг бүртгээгүй байсан зөрчлийг залруулж, тусгай зориулалттай материалын дансанд бүртгэлээ.

### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй

### 4.3 Албан шаардлага

- Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Тайлант онд 5.0 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө” заалт, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ,14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2.журналд бичих, 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5.санхүүгийн тайлан гаргах. УСНББОУС1,тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ
- Орон нутгийн өмчийн газар нь тус сургуулиас ирүүлсэн актлах хөрөнгийн жагсаалтын мөнгөн дүнг давтан шалгаж, хөрөнгийн бүртгэлтэй тулгаагүйн улмаас 2020 онд акталж дахин үнэлсэн 0.1 сая төгрөгийн хөрөнгийг 2021 онд дахин акталж, данснаас хасах аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол гаргуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйл, 77.2.1 Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах” заалттай нийцэхгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

### 4.4 Зөвлөмж

***1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

1.1. <u>Илрүүлэлт:</u> Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 534.4 сая төгрөгийн орлогын гүйлгээг байршуулаагүй.

1.2. <u>Эрсдэл:</u> Хуулийн хэрэгжилт хангаагүй байх

1.3. <u>Өгсөн зөвлөмж</u>: Хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасныг мөрдөж ажиллах



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Тайшир сумын Ерөнхий боловсролын сургууль | 5 | 7.7 | 1 | 2.5 | - | - | 3 | 5.2 | 1 | - |
| | **ДҮН** | **5** | **7.7** | **1** | **2.5** | **-** | **-** | **3** | **5.2** | **1** | |